



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 12

Улиастай

Шалгалт хийсэн дүнгийн тухай

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Шалгалтын үндэслэл, бүрэлдэхүүн, хугацаа:

2022 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албаны даргын баталсан 2022 оны 09 сарын 01-ний өдрийн 28 тоот удирдамжийн хүрээнд Ургамал сумын төсвийн байгууллагууд, ОНХС, СХС, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Батхүү, Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Т.Цэрэндолгор, Дотоод аудитор Б.Үүрийнтуяа нар 2022 оны 09-р сарын 17-оос 09-р сарын 21-ний өдрийн хооронд төлөвлөгөөт шалгалтыг хийж гүйцэтгэв.

1.2 Шалгуулагч байгууллага, хамрах хүрээ:

Ургамал сумын ИТХурал, ЗДТГазар, ОНХСан, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн 2020-2021 он, СХС-ийн 2011-2021 оны төсвийн бүрдэлт, зарцуулалт, өөрийн орлогын төвлөрүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, цалин тогтоолт, байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилт болон удирдамжид тусгагдсан асуудлууд хамрагдлаа.

1.3 Өмнөх шалгалтын талаар.

Өмнөх шалгалтын талаарх мэдээллийг хавсралтаар гаргав.

1.4 Шалгалтын явцад хийсэн ажил, үр дүн:

Ургамал сумын төсөвт байгууллагууд, сан, төсөл хөтөлбөрүүдийн 2020-2021 оны орлого, зарлага бүрийг анхан шатны баримт, бүртгэлтэй нь тулган баталгаажуулж зарим нэг үйл ажиллагааг гардан зохион байгуулсан албан хаагч нартай биечлэн уулзаж тайлбар тодруулага авах, санал хүсэлтийг сонсох зэрэг ажил зохион байгууллаа. Мөн байгууллагуудын удирдлагууд нягтлан бодогч нярав нарт шалгалтын талаар мэдээлэл өгч удирдамж танилцуулан, мэдээлэл хийлээ.

Шалгалтаар хууль, тогтоомж хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор Ерөнхий боловсролын сургуульд 1437,0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвд 872,8 мянган төгрөг, ИТХуралд 189,5 мянган төгрөг, ЗДТГ-т 1278,9 мянган төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 663,0 мянган төгрөг, Соёлын төвд 703,7 мянган төгрөг нийт 5144,9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, цаашид зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээний дүгнэлт, саналыг боловсруулан тусгаж тус байгууллагын удирдах болон бүртгэлийн ажилтан нарт шалгалтын талаар мэдээлэл өгч тэдний санал, хүсэлтийг сонслоо /дэлгэрэнгүйг хавсралтаар гаргав/.

Хоёр. Төсвийн орлого, зарцуулалтын байдал.

Төсөвт байгууллагуудын 2020, 2021 оны төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг хавсралтаар гаргав

Гурав. Санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал

3.1 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал:

ИТХ:

Үндсэн баримтгүй шатахууны шилжүүлсэн

Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ыг дутуу төлсөн, жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй

НДШ-ийг дутуу тайлагнасан

Цалин илүү олгосон

Томилолтын хуудасгүй томилолтын зардал шилжүүлсэн

ЗДТГ:

Гадны жолоочид сэлбэг хэрэгсэл авч өгсөн /дугуй/

Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ыг дутуу төлсөн, жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй

НДШ-ийг дутуу тайлагнасан

Цалин илүү олгосон

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн

Томилолтын хуудасгүй томилолтын зардал шилжүүлсэн

Ерөнхий боловсролын сургууль:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийдэг

Хүүхдийн тоог өсгөн хоолны зардлыг илүү гаргасан

Явсан ажлын тайлангүй шатахуун зарцуулсан

Хүүхдийн цэцэрлэг:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийдэг

Хүүхдийн тоог өсгөн хоолны зардлыг илүү гаргасан

Явсан ажлын тайлангүй шатахуун зарцуулсан

Эрүүл мэндийн төв:

Шатахууны бүртгэл тайланг хангалтгүй гаргасан, нягтлан бодогч нярав хоёр тооцоо нийлээгүй, эрхлэгч хянаж баталгаажуулаагүй

Шатахууны үлдэгдлийг тайланд тусгаагүй

Соёлын төв:

Амралтын цалин, үндсэн цалинг давхардуулан олгосон

Үндсэн баримтгүй интернэтийн үнэ шилжүүлсэн

Дөрөв. Дүгнэлт

4.1. Санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ:

-Шатахууны зарцуулалт, үр дүн, баримтын бүрдүүлэлтэд Санхүүгийн алба, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн онцгой анхаарч сар бүр зардлын гүйцэтгэлийн мэдээ авч дотоод хяналт хийж, эрх бүхий албан тушаалтны шийдвэртэй, албан томилолттой, явсан ажлын тайлантай ажилд шатахуун зарцуулдаг байх шаардлагатай байна.

-Байгууллагууд дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа, хяналтыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, түлш халаалт, хүнс, засварын материалын зарцуулалт дээр хяналт хийж баталгаажуулдаг байх.

-Шалгалтаар илэрсэн зөрчлийг шийдвэр гаргасан болон гардан зохион байгуулсан, түүнд хяналт тавих эрх, үүрэг бүхий албан тушаалтан нар хариуцах бөгөөд нөхөн төлбөрийн актыг хавсралтад нэр заагдсан хариуцагч нар төлнө.

4.2. Цаашид зохион байгуулж хэрэгжүүлэх ажил:

-Шилэн дансны мэдээллэл, улирлын тайланг хуулийн хугацаанд бүрэн байршуулах,

